

УЛААНБААТАР ХОТ
Бүх гишүүдийн хурлын
2021 оны 05-р сарын 22-ны өдрийн
07 тоот тогтоолоор батлав.

ГҮТБ
ТТГ3629 4 8019703

СОНГУУЛИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь сонгуулийн хороог байгуулах, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах зорилготой.
- 1.2 МХЗХҮХолбоо/цаашид холбоо гэх/-ны Тэргүүлэгчдийн болон Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн үүрэгтэйгээр Сонгуулийн хороог Бүх гишүүдийн хурал хуралдахаас 2 сарын өмнө холбооны ТЗХ-аас тогтоолоор батална.
- 1.3 Сонгуулийн хорооны ажиллагаа нь тухайн сонгууль зохион байгуулагдан, сонгогдсон гишүүд бүх гишүүдийн хурлаар батлагдсанаар дуусгавар болно.
- 1.4 Сонгуулийн хороо зохион байгуулсан ажлын тайлангаа бүх гишүүдийн хуралд танилцуулна.
- 1.5 Сонгуулийн хороог чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь холбооны болон гишүүн хоршоодын албан тушаалтнууд хөндлөнгөөс оролцох буюу нөлөөлөхийг хориглоно.
- 1.6 Сонгуулийн хороо сонгуулийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлын төсвийг тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар батлуулж, гүйцэтгэлийг тайлагнана.

Хоёр. Сонгуулийн үндсэн зарчим

- 2.1. Холбооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийг бүх гишүүдийн хурлаас нууц санал хураалтаар сонгоно.
- 2.2. Гишүүн хоршоо нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүх гишүүдийн хуралд биечлэн оролцох боломжгүй бол саналаа сонгуулийн хороонд албан ёсоор битүүмжлэн ирүүлж болно.
- 2.3. Сонгуулийн хорооны гишүүд нь нэр дэвшигчдийн талаар алив хэлбэрээр эерэг болон сөрөг сурталчилгаа хийхийг хориглоно.

Гурав. Сонгуулийн хорооны чиг үүрэг, хурлын ажиллагаа

- 3.1 Сонгуулийн хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болно.
- 3.2 Сонгуулийн хороо шийдвэрээ хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар гаргах ба гишүүдийн санал тэнцвэл хорооны даргын саналаар эцсийн шийдвэр гарна.
- 3.3 Сонгуулийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 3.3.1 нэр дэвшүүлэх ажиллагаа эхэлсэн талаар албан ёсоор зарлах, нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалыг хүргүүлэх;
 - 3.3.2 нэр дэвшигчдийг бүртгэх, холбогдох материалыг хүлээн авах;
 - 3.3.3 нэр дэвшигч нь хууль, дүрэмд заасан шалгуурт нийцэж байгаа эсэхийг тогтоох;
 - 3.3.4 нэр дэвшигчийн танилцуулгыг бэлтгэх, гишүүдэд хүргэх, бүх гишүүдийн хуралд танилцуулах;

- 3.3.5 бүх гишүүдийн хурлын үеэр сонгуулийн санал хураалтын үйл ажиллагааг удирдан явуулах, саналын хуудасны тооллогод хяналт тавих.
- 3.4 Сонгуулийн хороо нэр дэвшүүлэх ажиллагааг эхлэхээс өмнө холбогдох анкет, маягтуудыг боловсруулан бэлтгэл ажлаа хангасан байна.
- 3.5 Дүрэмд заасан шалгуурыг хангасан хоршоо болон хоршооны нэр дэвшигчийг бүртгэнэ.
- 3.6 Нэр дэвшигч хоршоо нь дараах материалыг сонгуулийн хороонд бүрдүүлж ирүүлнэ.
- 3.5.1 хоршооны танилцуулга
- 3.5.2 улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- 3.5.3 сүүлийн улирлын баталгаажсан санхүүгийн тайлангийн хуулбар
- 3.5.4 сүүлийн 3 жилийн гишүүний татвар төлсөн талаарх МХЗХҮХ-ны тодорхойлолт
- 3.5.5 холбооны үйл ажиллагаанд хоршоог төлөөлөх эрх бүхий этгээдийг томилсон тухай Тэргүүлэгчдийн зөвлөлийн тогтоол /хуралд оролцсон тэргүүлэгчдийн гарын үсгээр баталгаажсан байна/
- 3.5.6 эрх бүхий этгээдийн дэлгэрэнгүй анкет, иргэний үнэмлэх, боловсролын үнэмлэхний хуулбар, хоршооны тодорхойлолт
- 3.7 Сонгуулийн хороо ажлаа зохион байгуулахад шаардагдах мэдээллийг холбогдох газраас авч танилцах эрхтэй.
- 3.8 Сонгуульд нэр дэвшигч хоршоо болон хувь хүн нь баримт материалаа дутуу бүрдүүлсэн, энэ журмын 3.4-т заасан шалгууруудыг хангаагүй тохиолдолд сонгуулийн хороо түүний нэрийг дэвшүүлэхгүй талаар шийдвэр гаргаж, үндэслэл, шалтгааныг тухайн нэр дэвшигчид тайлбарласан байна. Энэ шийдвэрийг гишүүн хоршоо нь хүлээн зөвшөөрөхгүй бол гомдлоо холбооны хяналтын зөвлөлд гаргаж болно. Холбооны Хяналтын зөвлөлийн шийдвэр нь эцсийн шийдвэр байна.
- 3.9 Саналын хуудсанд нэр дэвшигчийг сонгуулийн хороонд баримт, материалаа бүрэн бүрдүүлж өгсөн бүртгэлийн дарааллаар жагсаана.
- 3.10 Бүх гишүүдийн хурал хуралдахаас 10 хоногийн өмнө сонгуулийн хороо нэр дэвшигчдийн товч танилцуулгыг гишүүн хоршоодод (хэвлэмэл болон цахим хэлбэрээр) урьдчилан хүргүүлнэ.
- 3.11 Бүх гишүүдийн хурал хуралдахаас 3 хоногийн өмнө саналын хуудас, санал хураах хайрцаг болон бусад бэлтгэлийг бүрэн хангасан байна.
- 3.12 Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон тооллогын комисс саналын хуудсыг тоолж, тогтоол үйлдэх ба сонгуулийн хороо санал хураалтын дүнг бүх гишүүдийн хуралд танилцуулж баталгаажуулах үүрэгтэй.
- 3.13 Ажлын тайлан, тоологдсон саналын хуудас, дүн, бусад бичиг баримтыг шаардлагын хэмжээнд бүрдүүлж архивлан, холбоонд хүлээлгэн өгснөөр сонгуулийн хорооны ажиллагаа дуусгавар болно.